

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/053/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 263533 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн Ерөнхий захирал: Ц.Жигдэн Утас: 70005401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 07/1191
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төслийн үйл ажиллагааны 2024 оны урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийслэлийн төсвөөс 476,360.5 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 458,756.9 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь аудит баталгаажуулалтын зардлаас 17,603.6 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна. Төсөл нь нийслэлийн санхүүжилтийг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт тусдаа санхүүгийн тайлангаар тайлагнадаг тул төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгадаггүй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төслийн бүрэлдэхүүн, хөтөлбөрийн хэрэгжилтэд гадаад эх үүсвэрээс 92,606,629.6 мянган төгрөг, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газраас 6,067,262.0 мянган төгрөг, нийт 98,673,891.6 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлж зарцуулсан байна.

Төслийн хүрээнд тайлант онд ашиглалтад орж улсын комиссын актаар 81,471,795.6 мянган төгрөгийн барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид шилжүүлж бүртгэлээс хассан байна.

Бусад асуудал

Төсөл нь хэрэгжсэнээр дараах 4 үр дүнд хүрэхээр боловсруулагдсан:

1. Тэргүүлэх ач холбогдол бүхий дэд төвүүдэд авто зам болон хотын дэд бүтцийн үйлчилгээ өргөжиж, тэдгээрийн хоорондын холболт сайжирна;
2. Зорилтот хэсгүүд дэх эдийн засгийн болон төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ;
3. Дэд бүтцийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааны үр дүн сайжирна;
4. Хот байгуулалт, хөтөлбөрийн менежмент, үйлчилгээг хүргэх чиглэлээр институци болон чадавх бэхэжнэ.

Хөтөлбөр гурван шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 66.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банкны ажлын хэсэг төслийн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан бөгөөд төслийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлуудыг холбогдох талуудтай хэлэлцэн Азийн хөгжлийн банкнаас төслийг санхүүжүүлэх хугацааг 2026 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хүртэл, Европын хөрөнгө оруулалтын банкнаас төслийг санхүүжүүлэх хугацааг 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хүртэл тус тус сунгасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	468,500,365,089.48	483,982,480,017.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	23,078,623,414.10	33,073,134,794.65
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	23,078,623,414.10	33,073,134,794.65
31210	Төгрөг	490,231,169.82	494,823,321.17
31211	Төрийн сангийн харилцах	490,231,169.82	494,823,321.17
31220	Гадаад валют	22,588,392,244.28	32,578,311,473.48
31221	Төрийн сангийн харилцах	22,565,118,241.43	32,554,972,218.70
31223	Арилжааны банк дахь харилцах	23,274,002.85	23,339,254.78
33	АВЛАГА	7,977,288.56	29,999,344.21
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	22,062.08
33500	Бусад авлага	7,977,288.56	29,977,282.13
33510	Байгууллагаас авах авлага	7,977,288.56	29,977,282.13
34	УРЬДЧИЛГАА	334,548,457.21	16,477,259,196.07
34600	Урьдчилж гарсан зардал	334,548,457.21	16,477,259,196.07
35	БАРАА МАТЕРИАЛ	10,757,113.75	10,820,422.87
35470	Бусад хангамжийн материал	10,757,113.75	10,820,422.87
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	445,068,458,815.86	434,391,266,259.4
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	445,068,458,815.86	434,391,266,259.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	27,810,910.11	34,157,580.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,810,910.11	34,157,580.63
39200	Биет хөрөнгө	27,810,910.11	34,157,580.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,950,000.00	113,950,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(96,857,499.84)	(108,252,499.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	84,381,500.00	109,569,818.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(84,381,499.92)	(91,502,886.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,063,279.90	80,111,956.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	(62,344,870.03)	(69,718,807.81)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	468,528,175,999.59	484,016,637,597.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	45,322,195,648.61	38,773,316,901.46
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	45,322,195,648.61	38,773,316,901.46
41300	Өглөг	23,432,177,042.00	7,007,724,546.05
41310	Ажиллагсадтай холбогдсон өглөг	75,714.53	146,944.72
41361	Байгууллагад төлөх өглөг	23,431,835,327.47	7,007,543,343.43
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	266,000.00	-
41363	Татвар, НДШ-ийн өглөг	-	34,257.90
41400	Урьдчилж орсон орлого	21,890,018,606.61	31,765,592,355.41
41440	Бусад урьдчилж орсон орлого	21,890,018,606.61	31,765,592,355.41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	423,205,980,350.98	445,243,320,696.3
51	Засгийн газрын хувь оролцоо	423,205,980,350.98	445,243,320,696.3
51200	Хуримтлагдсан үр дүн	423,205,980,350.98	445,243,320,696.3
51210	Өмнөх үеийн үр дүн	378,868,105,346.88	423,189,583,207.8
51220	Тайлант үеийн үр дүн	44,320,335,004.10	22,020,847,947.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,540,000.00	32,889,540.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	468,528,175,999.59	484,016,637,597.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	66,138,189,616.14	104,794,959,481.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,564,058,259.14	98,727,697,462.89
120	Нийтлэг татварын бус орлого	54,564,058,259.14	98,727,697,462.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	54,564,058,259.14	98,727,697,462.89
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	51,398,722,572.24	92,606,629,646.11
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,109,024,586.90	6,114,767,816.78
120009	Бусад орлого	56,311,100.00	6,300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,574,131,357.00	6,067,262,019.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,574,131,357.00	6,067,262,019.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	11,574,131,357.00	6,067,262,019.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	22,081,972,986.16	82,850,760,961.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,081,972,986.16	82,850,760,961.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,081,972,986.16	82,850,760,961.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	970,307,639.38	1,345,578,695.90
210105	Гэрээт ажлын хөлс	970,307,639.38	1,345,578,695.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	258,803.00	170,857.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	258,803.00	170,857.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,111,406,543.78	81,505,011,407.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,086,858,549.14	81,479,121,083.55
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,547,994.64	25,890,324.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	44,056,216,629.98	21,944,198,520.63
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	488,168,885.86	158,899,930.43
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	488,168,885.86	158,899,930.43
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	224,050,511.74	82,250,503.15
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	224,050,511.74	82,250,503.15
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	44,320,335,004.10	22,020,847,947.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	22,480,638,221.40	49,393,877,284.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,480,638,221.40	49,393,877,284.35
120	Нийтлэг татварын бус орлого	22,480,638,221.40	49,393,877,284.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,480,638,221.40	49,393,877,284.35
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	22,424,327,121.40	49,387,577,284.35
120009	Бусад орлого	56,311,100.00	6,300,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,610,596.56	25,950,772.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,610,596.56	25,950,772.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,610,596.56	25,950,772.39
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	258,803.00	170,857.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,351,793.56	25,779,914.64
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,438,027,624.84	49,367,926,511.96
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	27,405,013,528.85	39,358,488,807.64
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,405,013,528.85	39,358,488,807.64
226001	Гадаад эх үүсвэрээр	27,405,013,528.85	39,358,488,807.64
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VI)	(27,405,013,528.85)	(39,358,488,807.64)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	184,410,048.12	26,671,548.31
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	197,927,810.95	41,597,872.08
VIII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(13,517,762.83)	(14,926,323.77)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(4,980,503,666.84)	9,994,511,380.55
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,059,127,080.94	23,078,623,414.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23,078,623,414.10	33,073,134,794.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	17,540,000.00	378,868,105,346.8	378,885,645,346.88
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	17,540,000.00	378,868,105,346.8	378,885,645,346.88
Тайлант үеийн үр дүн	-	-	44,320,335,004.10	44,320,335,004.10
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	17,540,000.00	423,188,440,350.9	423,205,980,350.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,142,856.91	1,142,856.91
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	17,540,000.00	423,189,583,207.8	423,207,123,207.89
Тайлант үеийн үр дүн	-	-	22,020,847,947.90	22,020,847,947.90
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	15,349,540.58	-	15,349,540.58
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	32,889,540.58	445,210,431,155.7	445,243,320,696.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	87,492,897,000.00	87,166,100,463.13	326,796,536.87	99.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	87,492,897,000.00	87,166,100,463.13	326,796,536.87	99.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	87,492,897,000.00	87,166,100,463.13	326,796,536.87	99.6
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	87,492,897,000.00	87,166,100,463.13	326,796,536.87	99.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	87,492,897,000.00	87,166,100,463.13	326,796,536.87	99.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	87,492,897,000.00	87,166,100,463.13	326,796,536.87	99.6
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	87,492,897,000.00	87,166,100,463.13	326,796,536.87	99.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,059,127,080.94	23,078,623,414.10	4,980,503,666.84	82.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23,078,623,414.10	33,073,134,794.65	(9,994,511,380.55)	143.3
Байгууллагын тоо	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	26	21	5	80.7
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	25	20	5	80.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 29,869.1 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сонгинохайрхан дүүрэгт байрлах Баянхошуу дэд төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн барилгын өртгийг 14,479.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн.	1	14,479.2			1	14,479.2	1	14,479.2				
Барьцааны өр төлбөрийн үлдэгдлийг Монгол банкны хаалтын ханшаар тэгшитгээгүйгээс 4,144.8 мянган төгрөгийн барьцааны өглөгийг дутуу бүртгэсэн.	1	4,144.8			1	4,144.8	1	4,144.8				
Гадаад валютаарх зээлийн орлогыг бүртгэхдээ огноо андуурч 11,245.1 мянган төгрөгийн орлого илүү бүртгэсэн.	1	11,245.1			1	11,245.1	1	11,245.1				
Дүн	3	29,869.1			3	29,869.1	3	29,869.1				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 16,309,578.3 мянган төгрөгийн зөрчил² илрүүлж, 4 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2023 оны 10 дугаар сарын 3-ний өдөр Дамбадаржаа Дулааны Станц төслийн хүрээнд баригдаж байгаа барилга угсралтын 23,463,368.72 ам долларын ажлыг 660 хоногт багтаан гүйцэтгүүлэхээр ДАНР дугаар бүхий гэрээг China second metallurgy group компанитай байгуулж урьдчилгаа төлбөрийн 20.0 хувь буюу 16,142,750.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон. Батлагдсан төлөвлөгөө болон гэрээний дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар уг барилга угсралтын ажлын явц 35.0 хувь байх ёстой байсан ч, бодит гүйцэтгэл 6.0 хувьтай, ажил удааширсан, төслийн зээлийн үр дүн хангалтгүй байна.	1	16,142,750.7			1	16,142,750.7						
Байгууллага нь Тэгш Агь Констракшн ХХК болон Ай Ди Си Проперти ХХК-ийн түншлэлтэй барилга угсралтын ажил гүйцэтгүүлэх DDСD-ВКН дугаартай гэрээг 2021 онд байгуулсан. 2022-2023 онд тус ажил зогссон, ажлын гүйцэтгэл хангалтгүй байсан тул өмнөх оны аудитаар уг асуудлыг шийдвэрлэж ажиллах талаар зөвлөмж өгсөн. 2024 оны байдлаар зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, ажил зогсонги байдалтай, ажил хийгдээгүй хэвээр байна.	1	-			1	-						
Байгууллага нь Цаст Констракшн ХХК-тай барилга угсралтын ажил гүйцэтгүүлэх ASKG-ВКН дугаартай гэрээг 2021 онд байгуулсан. 2022-2023 онд тус ажил зогссон, ажлын гүйцэтгэл хангалтгүй байсан тул өмнөх оны аудитаар уг асуудлыг шийдвэрлэж	1	-			1	-						

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

ажиллах талаар зөвлөмж өгсөн. 2024 оны байдлаар зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, ажил зогсонги байдалтай огт ажил хийгдээгүй хэвээр байна.												
Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь Азийн Хөгжлийн Банкны буцалтгүй тусламжаар хийгдсэн 8,945,973.9 мянган төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 9 сарын 28-ний өдрийн 124 дүгээр тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн бөгөөд ашиглагч байгуулага "Ус Сувгийн Удирдах Газар"-тай тулган баталгаажуулахад 166,827.6 мянган төгрөгөөр дутуу байна.	1	166,827.6			1	166,827.6						
Дүн	4	16,309,578.3			4	16,309,578.3			-	-	-	-